

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 дугаар
сарын 01-ны өдөр

Дугаар А-163

Улаанбаатар
хот

Төсөлд дэмжлэг үзүүлэх тухай

Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”-ын 4.2, 4.3, 4.4 дэх заалт, Ажлын хэсгийн 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлын тэмдэглэл, мөн өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд зээлийн дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүд, тэдгээрт олгох зээлийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Барьцаа хөрөнгийн шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй 5 жилийн хугацаатай, жилийн 3.6 хувийн хүүтэй, эхний жил үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээ байгуулж, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сан /Д.Пүрэвцэрэн/-д даалгасугай.

3. Зээл олгоход шаардагдах 509.000.000 /Таван зуун есөн сая/ төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-179 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.36-т заасан зардлаас санхүүжүүлэхийг Мал хамгаалах сан /Д.Пүрэвцэрэн /-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Батмөнх/-т үүрэг болгосугай.

САЙД

Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн
А-163 дугаар тушаалын хавсралт

ЗЭЭЛИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ СҮҮНИЙ ҮХЭР
ҮРЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

№	Аймаг, хотын нэр	Сум, дүүргийн нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Төсөлд олгох зээл /сая.төг/
1	Улаанбаатар	Баянзүрх	“Мөнх цаст Очирваань” ХХК	20.0
2	Улаанбаатар	Баянзүрх	“Тансаг таатай Орчин” ХХК	20.0
3	Улаанбаатар	Баянзүрх	“Монголын ногоон хөгжлийн судалгаа, шинжилгээ үйлдвэрлэлийн хүрээлэн” ХХК	20.0
4	Улаанбаатар	Баянзүрх	“Алтай Орхон” ХХК	20.0
5	Улаанбаатар	Баянзүрх	“Гүн тамга” ХХК	20.0
6	Улаанбаатар	Баянзүрх	“Баянзүрх Хангай” ХХК	20.0
7	Улаанбаатар	Баянгол	“Меаттрейд” ХХК	20.0
8	Улаанбаатар	Баянзүрх	“Брайт гламоур” ХХК	17.0
9	Улаанбаатар	Баянгол	“Бэст Эвэнт” ХХК	20.0
10	Улаанбаатар	Баянгол	“Хөх ташуу” ХХК	20.0
11	Улаанбаатар	Сүхбаатар	“Шанагын Буудай” ХХК	20.0
12	Улаанбаатар	Сүхбаатар	“Эй Эйч ди Би” ХХК	17.0
13	Улаанбаатар	Сүхбаатар	“Хүү - Эрдэнэ” ХХК	20.0
14	Улаанбаатар	Хан-Уул	“Өвтийн зам” ХХК	20.0
15	Улаанбаатар	Чингэлтэй	“Амар брэнч” ХХК	10.0
16	Улаанбаатар	Чингэлтэй	“Товхон хайрхан” ХХК	20.0
17	Улаанбаатар	Сонгинохайрхан	“Монсүү” ХХК	15.0
18	Улаанбаатар	Сонгинохайрхан	“Лун шянь интернэшил” ХХК	20.0
19	Дархан-Уул	Дархан	“Опрэн” ХХК	20.0
20	Дархан-Уул	Хонгор	“Бамхий” ХХК	15.0
21	Дархан-Уул	Дархан	“Энх Сүрэг үнээний фермер” ХХК	20.0
22	Орхон	Баян-Өндөр	“Эрдэнэт Газрын Өгөөж” хоршоо	20.0
23	Төв	Баянцогт	“Хан Хөхийн Оргил” ХХК	20.0
24	Төв	Лүн	“Ургацын жигүүр” ХХК	15.0
25	Сэлэнгэ	Ерөө	“Эзэн сүрэг хоршоо” хоршоо	20.0
26	Сэлэнгэ	Баянгол	“Түшигбаянгол” ХХК	20.0
27	Сэлэнгэ	Сүхбаатар	“Чоносбүргэд” ХХК	20.0
НИЙТ ДҮН				509.0

.....оОо.....